



**ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ**

2007 оны 12 дугаар сарын 26-ны  
өдөр

Улаанбаатар хот

**Дугаар 354**

Төрийн албаны тухай хуулийн 7.10, 9.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас  
ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг 1 дүгээр хавсралтын, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг 2 дугаар хавсралтын, мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг 3 дугаар хавсралтын, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг 4 дүгээр хавсралтын, эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг 5 дугаар хавсралтын, соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг 6 дугаар хавсралтын, төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын ангилал, зэрэглэлийг 7 дугаар хавсралтын, хилийн чанадад ажиллах нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг 8 дугаар хавсралтын ёсоор тус тус баталж 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. (Засгийн газрын 2012-05-02-ны өдрийн 152 дугаар тогтоолоор 5 дугаар хавсралт, Засгийн газрын 2015 оны 441 дүгээр тогтоолоор 1 дүгээр хавсралтад тус тус нэмэлт орсон. Засгийн газрын 2016 оны 278 дугаар тогтоолоор 8 дугаар хавсралтыг нэмсэн бөгөөд үүнийг 2016-6-1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Засгийн газрын 2018 оны 263 дугаар тогтоолоор 4, 5 дугаар хавсралтад нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд үүнийг 2018-9-1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Засгийн газрын 2018 оны 263 дугаар тогтоолоор 6 дугаар хавсралтыг 2018-9-1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсон)

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 236 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд С.БАЯР  
Сангийн сайд Ч.УЛААН  
Нийгмийн хамгаалал,**

хөдөлмөрийн сайд Д.ДЭМБЭРЭЛ